



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2022 оны 06 сарын 08 өдөр

Дугаар 338

Улаанбаатар хот

┌ Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх ┐
тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.2.1, Аж ахуйн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.4, Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.2.2, Санхүүгийн зохицуулах хорооны 2019 оны 370 дугаар тогтоолоор баталсан “Банк бус санхүүгийн байгууллагын үйл ажиллагаанд эрсдэлд суурилсан хяналт шалгалт хийх журам”-ын 6.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Баян агула ББСБ” ХХК-ийн банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсүгэй.

2. Тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд гаргасан зөрчлөө арилгаж, энэ талаар Санхүүгийн зохицуулах хороонд мэдэгдээгүй тохиолдолд банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох арга хэмжээ авахыг “Баян агула ББСБ” ХХК /Г.Мөнгөнцэцэг/-д анхааруулсугай.

3. Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийт болон харьяалагдах татварын алба, Улсын бүртгэлийн ерөнхий газарт ажлын 10 хоногийн дотор мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН